

Сэрэгтүн

Сансар ертөнцийн Фа ариусгал дууслаа, одоо Фа хүний ертөнцийг ариусгах шилжилт болж байна. Фа хүний ертөнцийг ариусгах үед Дафа-гийн ихэнх сурагчид Багшийгаа дагалдах болно.

Гэхдээ энэ явцад, маш их үйлийн үртэй олон амь бодиуд, түүнчлэн харгис коммунист намыг дагагчид арчигдана, бүрэн устгагдах болно. Үүний зэрэгцээ, Дафа-гийн сурагчдын дунд, хүний орчлонд ирэхдээ амь насаараа өргөсөн тангаргаа биелүүлээгүй хүмүүс, жишээлбэл: Дафа-гийн сурагчдын хийх ёстой зүйлийг сайн хийдэггүй, хүн аврах үйлст оролцдоггүй, хүний сэтгэлд хүчтэй автсанаас сурагчдын бясалгалын орчинд удаан хугацааны турш сөрөг нөлөө үзүүлсэн, мөн Фа-гийн замаас гажсан хүмүүсийг дагалдсан эсвэл сурагчийн дүр үзүүлсэн ХКН-ын нууц туршуулуудыг дагаж бусдад ноцтой хор уршиг учруулж байсан хүмүүс бүгд өргөсөн тангаргынхаа дагуу хариуцлага хүлээх болно. Тодорхой хэлбэл, зууралдсан сэтгэлдээ хүчтэй автсан, гэхдээ үүндээ анхаардаггүй удаж байгаа хүмүүс, сурагч мэт дүр эсгэдэг туршуулуудын бай болдог. Тэд урхинд нь улам гүнзгий орж бусдын зөвлөлгөөг сонсдоггүй. Жишээлбэл, Сингапураас Япон руу зугтсан эмэгтэйн тухай би ярьсан, гэвч зарим хүмүүс одоо болтол үүнийг ухамсарлахгүй хэвээр байна. Тэр үед би нэрийг нь дурдаагүй, түүнд нэрээ дуудуулах ч эрх байхгүй. Тэр өөрийгөө их хичээнгүй харагдуулдаг, эелдэг зөөлөн дүр үзүүлж хүмүүсийг хуурахдаа сайн. Хэсэг хүмүүс тэр эмэгтэйд дагалдаж, тэдний ойлголт нь түүний адил бидний номоос гажсан. Тэдний зарим нь түүнийг ер бусын чадвартай гэж биширдэг, түүнд нь хууртагдсан. Тэрээр өмнөх амьдралдаа ийм, тийм хүмүүстэй хувь тавилангийн холбоотой байсан гэж байнга ярьдаг. Түүний эрчүүдэд сээтэн хаяж хэлсэн үгэнд нь зарим сурагчдын сэтгэл нь татагдаж итгэгчидэг. Одоо эдгээр хүмүүс хамгийн их аюулд байна.

Мөн өөр хэсэг сурагчид байдаг, тэдний дунд бас хуучин сурагчид бий. Тэд Дафа-гийн үйл хэрэгт тогтмол оролцдог, Фа-д байнга суралцдаг боловч эгзэгтэй мөчид зарим бэрхшээлийг даван туулж чаддаггүй. Та нарын бясалгадаг Дафа бол орчлон ертөнцийн бүх амь бодийг бүтээсэн, аугаа Бурхдыг бүтээсэн, мөн хамгийн өчүүхэн вирус, бактерийг бий болгосон юм. Та нар Дафа-гийн бясалгагчид, хүмүүнийг аврахад Багшдаа тусалж байгаа. Хүнийг аврах явцад халдварт өвчнөөс хэдэн зуу дахин, хэдэн мянга дахин хүчтэй вирус, бактерийг устгахад олон

хүмүүст тусалсан. Гэсэн хэдий ч та нар цар тахлын асуудалд өөрийнхөө түвшинд зөв хандаж чадахгүй байна. Зарим сурагчид халдвар авахаас айдаг, харин зарим нь вакцин хийлгэхээс эрс татгалздаг. Аль ч тохиолдолд ч, "Дафа-гийн сурагч" гэсэн нэрэндээ нийцэж байна уу гэж өөрөөсөө асуу. Зарим эмэгтэй сурагчид жирэмсэн, мэдээж тэд үүнд бас багтана. Би та нарт вакцин хийлгэх эсэх, мөн цар тахал та нарт хэрхэн нөлөөлж болох талаар хэлээгүй. Аль ч тал руу туйлширч болохгүй, энэ нь хүний сэтгэлээс үүдэлтэй. Миний та нарт хэлэх гэсэн зүйл бол: Та нар өөрсдийгээ энгийн хүний байр сууриас харж байна, бясалгагч хүний байр сууриас асуудалд хандахгүй байна. Энэ нь та нарын бясалгалд дутагдал байгаатай холбоотой юм.

Одоо бидний дунд, улс төрийн үйл явдалд болон энгийн хүний маргаантай асуудалд их автсан хүмүүс байна. Бид юу хийхийн тулд энд байгаагаа мартаж болохгүй. Нийгмийн байдлыг өөрчлөх нь та нарын үүрэг биш. Өнөөгийн нийгэм эцсийн төгсгөлдөө тулж ирсэн, мөн болж буй бүх муу үзэгдлүүд бол зайлшгүй. Бидний хийж байгаа бүх зүйл бол хүмүүсийг аврахын тулд юм. Хуучин ертөнц бол ийм л юм, болдгоороо л болог. Шинэ ертөнц рүү амь бодийг аврахад та нарын үүрэг хариуцлага оршиж байна. Фа хүний орчлонг ариусгах дараагийн түүхт эрин үеийн тулд хийгдэх ёстой зүйл бол - хүмүүнийг аварч Фа-гаар ариусгагдсан орчлон руу хүргэх, мөн уламжлалт соёл, ёс заншлыг сэргээх явдал юм. Фа чуулган болоогүй удсан ч миний хэлэх гэсэн зүйл бол ялгаагүй, та нарыг бясалгалынхаа аяндаа зөв замаар замнаж, улмаар түүхийн үүр цайхаас өмнө өргөсөн тангаргаа биелүүлэхэд тань туслахын тулд юм. Та нар энэ аяныхаа замд олон тооны саад бэрхшээлийг туулж ирсэн, харин хамгийн эцэст нь бүдэрч унах ёсгүй. Хэдийгээр зарим хүмүүс ахин дахин бодлогогүй тэнэг зүйл хийдэг ч "Дафагийн сурагч" гэсэн нэрийг Бурхад хүртэл биширдэг юм.

Ли Хонжи
2021 оны арван нэгдүгээр сарын 18